



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/13

Арвайхээр

### Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.б, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч: Г.Баясгалан -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Г.Бүрэнтөгс- аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Гишүүд: Ц.Алтан-Эрдэнэ –аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч  
Ц.Идэрсайхан -аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын Төсөв санхүү хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Мөнхбат -аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дэд бүтэц бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн


Сумын Засаг дарга нар

Д.Лхам-Оролмаа –“Өвөрхангай-АЗЗА” ТӨХК-ний захирал

Ц.Төмөрбаатар -Арвайхээр сум Хотын Захирагчийн албаны ерөнхий менежер

2. Зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч, салбар хоорондын ажлын уялдааг хангаж ажиллахыг ажлын хэсэг (Г.Баясгалан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100027

D:My Doc. Zahiramj. Zasaga darga